



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2012 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 157

Мандалговь

Орон сууц худалдах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дугаар зүйлийн 19.1.2 дахь заалт, Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.5, Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Орон сууцнуудыг эзэмшин ашиглуулж байгаа Аймгийн ЗДТГ-ын тухайн байгууллагуудыг өөрийн гэсэн орон сууцтай болгох санал, өмч хамгаалах комиссын дүгнэлтийг харгалзан хавсралтанд заасан 30, 32-р байрны 10 айлын орон сууцыг худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Орон сууцнуудын худалдах үнэ 241799,0 мянган төгрөгийг зохих эзэмшигчдээс 2013 оны 6 сард багтаан төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлж оруулахыг Орон нутгийн өмчийн албаны дарга /Ш.Батсүх/-д үүрэг болгосугай.

3. Тухайн байгууллага авах боломжгүй бол дуудлага худалдаагаар худалдахыг Орон нутгийн өмчийн албаны дарга /Ш.Батсүх/, Аймгийн ЗДТГ-ын дарга /О.Чулуунбат/ нарт даалгасугай.

4. Худалдсан орон сууцнуудыг зохих журмын дагуу бүртгэлээс хасахыг Аймгийн ЗДТГ-ын дарга /О.Чулуунбат/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц. МӨНГӨНЦООЖ

